



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН
УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН **2022**

Эрүүл мэндийн мэдээллийн тогтолцоонд сувилагч тусгай мэргэжилтний үүрэг оролцоо


Б Мидэрсүрэн / ЭМГ. ХШҮМХ-н дарга



Агуулга




Сувилагч тусгай мэргэжилтний хүний нөөцийн товч статистик



АГУУЛГА



Эрүүл мэндийн мэдээллийн тогтолцооны товч танилцуулга, сувилагч тусгай мэргэжилтний оролцоо



Үйл ажиллагааны товч статистик, цаашид анхаарах асуудал



Сувилагч тусгай мэргэжилтний хүний нөөцийн ТОВЧ СТАТИСТИК


ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН
УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН **2022**

Байгууллага	тоо	Нийт ажиллагса д	Сувилагч тусгай мэргэжилтэн	Эзлэх хувь
Эрүүл мэндийн салбар	110	956	382	40.0
Салбарын бус байгууллага	25	66	32	48.5
Нийт	135	1022	414	40.5

Эмнэлгийн сувилагч тусгай мэргэжилтэний бүтэц




Нийт сувилагч тусгай мэргэжилтэний эзлэх хувь






Сувилагч тусгай мэргэжилтний хүний нөөцийн ТОВЧ СТАТИСТИК

НИЙТ СУВИЛАГЧ ТУСГАЙ МЭРГЭЖИЛТНИЙ



Сувилагч тусгай мэргэжилтэний насны байдал







Сувилагч мэргэжилтний хүний нөөцийн ТОВЧ СТАТИСТИК

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН
УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН **2022**

Нийт 192 сувилагч



Мэргэшсэн сувилагч мэргэжлийн төрлөөр нь






Сувилагч мэргэжилтний хүний нөөцийн товч статистик

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН
УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН **2022**

Сувилагч тусгай мэргэжилтний шилжилт хөдөлгөөн

Тайлангийн эхэнд байсан		414
Нэмэгдсэн		84
Үүнээс:	Төгсөж ирсэн	11
	Шинээр ажилд орсон	33
	Шилжиж ирсэн	20
	Жирэмсний болон хүүхэд асрах чөлөөнөөс орсон	20
Хасагдсан		84
Үүнээс:	Өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн	30
	Эрүүл мэндийн байгууллага хооронд шилжсэн	17
	Тэтгэвэрт гарсан	13
	Нас барсан	3
	Группэд орсон	0
	Жирэмсний болон хүүхэд асрах чөлөө авсан	15
	Бусад шалтгаанаар /халагдсан/	6
Тайлангийн эцэст байгаа		414

Мэргэжлийн зэрэгтэй СТМ-71/ 17,1%






Статистикч мэргэжилтний хүний нөөцийн товч статистик / өмнөговь 22/

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН
УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН **2022**


Статистикч эмч нарын үндсэн мэргэжил



Давхар ажил эрхэлдэг.

- Бичиг хэрэг, архив / ТЗ, Магадлан, бусад тайлан/
- Багын эмч
- НЭМА
- Даатгал
- Үзлэг, дуудлага, ээлжийн сувилагч
- ЭЭСангийн эрхлэгч

Статистикч мэргэжлээр ажилласан



Асуудал

- 4 байгууллагын мэргэжилтнүүд байнга солигдож жил бүр сургалт, дадлага авдаг. Олгох курс хийгдээгүй.
- 8 байгууллагын мэргэжилтнүүд ойрын 1-2 жилдээ тэтгэвэрт гарна.
- Давхар ажил эрхэлдэгээс мэдээллийн чанарт нөлөөлдөг.
- Ажлын ачаалал их, ажил нь үнэлэмж муутайгаас шалтгаалан халшрах



БҮРТГЭЛИЙН МАЯГТ

Эрүүл мэндийн байгууллагад өдөр тутам хийгдэж байгаа эмчийн үзлэг, оношлогоо, шинжилгээ, эмчилгээ, сувилгаа зэрэг аливаа ажил үйлчилгээг зориулалтын батлагдсан маягт дээр тэмдэглэсэн баримтыг эмнэлгийн бүртгэлийн маягт гэнэ.

Бүртгэлийн маягт нь:

- ✓ Шинжилгээ судалгаа болон албан хэргийн үнэт баримт
- ✓ Эмнэлгийн тусламж үйлчилгээг тухайн нөхцөлд нь тэмдэглэсэн цаг хугацааны тэмдэглэл, түүхийн баримт бичиг
- ✓ Мөн эмнэлгийн ямар ч үзлэг, эмчилгээ, үйлчилгээ нь зөвхөн анагаах ухааны зохих мэргэжил эзэмшсэн хүмүүст хууль ёсоор зөвшөөрөгдөж, тэдэнд олгогдсон эрх хэмжээний дагуу хийгддэг учраас үнэн зөв хөтлөгдсөн эмнэлгийн бүртгэлийн маягтууд нь мэргэжлийн ба хуулийн чухал баримт болдог./ *ач холбогдлын түвшингээр архивлан хадгалах хугацаа заасан байдаг/*



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН
УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН 2022



2019 оны 12 сарын 30 өдөр

Дугаар А/611

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн салбарын статистик мэдээ,
мэдээллийн журам, бүртгэлийн маягтыг
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.19, Статистикийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 (з) дахь хэсгийг тус тус үндэслэн эрүүл мэндийн мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн мэдээллийн мэргэжилтэн, биостатистикч эмчийн эрх, үүргийг нэгдүгээр, эрүүл мэндийн салбарын албан ёсны статистикийн мэдээ тайлан гаргах, мэдээлэх журмыг хоёрдугаар, хувийн хэвшлийн эмнэлгийн мэдээ, тайлан гаргах, мэдээлэх журмыг гуравдугаар, халдварт өвчин, хамшинж, сэжигтэй тохиолдлыг бүртгэх, мэдээлэх журмыг дөрөвдүгээр, бэлгийн замаар дамжих халдварын тохиолдлыг бүртгэх, мэдээлэх журмыг тавдугаар, сүрьеэ өвчнийг бүртгэх, мэдээлэх журмыг зургаадугаар, хорт хавдрыг бүртгэх, мэдээлэх журмыг долоодугаар, хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийг бүртгэх, мэдээлэх журмыг наймдугаар, уламжлалт анагаахын тусламж, үйлчилгээний мэдээг бүртгэх, мэдээлэх журмыг есдүгээр, эрүүл мэндийн бүртгэлийн болон тайлангийн маягтын жагсаалт, хадгалах хугацааг аравдугаар, шинэчлэн боловсруулсан анхан шатны бүртгэлийн болон тайлангийн маягтын загварыг арваннэгдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Бүртгэл, тайлангийн шинэчлэгдсэн маягтын загвар, хөтлөх зааврыг шинэчлэн боловсруулж, хэвлүүлэх, маягтад өөрчлөлт орсонтой холбогдуулан эрүүл мэндийн статистикийн програм хангамжийг шинэчлэх үйл ажиллагааг тус тус 2020 оны 1 дүгээр сард багтаан зохион байгуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д даалгасугай.

3. Бүртгэл, тайлангийн маягуудыг хэвлүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн төсөвт тусгах, өвчний түүхийг архивлах, хадгалах өрөөг орчин үеийн шаардлагад нийцсэн тоног төхөөрөмжөөр тоноглохыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын болон өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

4. Тушаалыг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Я.Амаржаргал/-т даалгасугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2012 оны 95, 2013 оны 446 дугаар тушаалын 3, 4, 5, 6, 7 дугаар хавсралт, 2013 оны 450 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД  Д.САРАНГЭРЭЛ



ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН
УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН **2022**

- Монгол Улсын “Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай” хууль
- Монгол Улсын “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай” хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.6 дахь заалт
- Монгол Улсын “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь заалт
- Элэг бүтэн Монгол үндэсний хөтөлбөр хэрэгжилтийг үнэлэх, дүгнэх
- Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Номхон далайн баруун бүсийн мэдээний санд орох Монгол улсын эрүүл мэндийн үзүүлэлтээс тооцогдохгүй байгаа мэдээллийг гаргах
- Тогтвортой хөгжлийн зорилтын олон улсын болон үндэсний түвшний үзүүлэлтийг тооцох.
- Үндэсний болон олон улсад мөрдөж буй ангилал кодыг мөрдөх.
- Тоо мэдээллийг жижиг нутаг дэвсгэр буюу сумын түвшний задаргааг гарган тайлагнах



НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ/ жишээ/

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН
УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН **2022**

- Өрх, сумын эрүүл мэндийн төвүүдэд өдрийн эмчилгээ хийгдэж эхэлсэнтэй холбогдуулан Хүүхэд, насанд хүрэгчдийн
“**Өдрийн эмчилгээний бүртгэл**”-ийг шинээр боловсруулсан.
- “**Эрүүл шүд-Эрүүл хүүхэд**” үндэсний хөтөлбөр батлагдан гарсантай холбогдуулан, амны хөндийн эрүүл мэндийн бүртгэл, мэдээллийг сайжруулах зорилгоор
- “**Нүүр амны эмчлэгч эмчийн эмчилгээний бүртгэл**” АМ-37,
- **Нүүр амны мэс заслын эмчийн эмчилгээний бүртгэл АМ-38,**
- **Нүүр амны согог заслын эмчийн эмчилгээний бүртгэл АМ-39,**
- **Нүүр амны гажиг заслын эмчийн эмчилгээний бүртгэл АМ-40,**
- **Нүүр амны урьдчилан сэргийлэх үзлэгийн бүртгэл АМ-41 маягтуудыг боловсруулсан**



НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ/ жишээ/

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН
УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН 2022

- Халдварт, халдварт бус өвчний эрт илрүүлгийн маягтыг шинэчлэн боловсруулсан бөгөөд
- 5 хүртэлх насны хүүхдийн эрт илрүүлэг үзлэгийн маягт ЭИМ-1,
- Өсвөр насны хүүхдийн эрт илрүүлэг үзлэгийн маягт ЭИМ-2
- Насанд хүрэгчдийн эрт илрүүлэг үзлэгийн маягт ЭИМ-3

Эмчийн үзлэгийн бүртгэлд урьдчилан сэргийлэх болон эрт илрүүлгийн үзлэгийг ICD-10-р ангиллын дагуу кодлон бүртгэж ялгаж, тайлан гаргах боломжтой болсон.



ХАВСРАЛТ 11

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН
УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН **2022**

1. Эрүүл мэндийн мэдээллийн мэргэжилтэн, биостатистикч эмчийн **эрх, үүрэг**
2. Эрүүл мэндийн салбарын албан ёсны статистикийн мэдээ тайлан гаргах, мэдээлэх журам
3. **Хувийн хэвшлийн** эмнэлгийн мэдээ, тайлан гаргах, мэдээлэх журам
4. Халдварт өвчин, хамшинж, сэжигтэй тохиолдлыг бүртгэх, мэдээлэх журам
5. Бэлгийн замаар дамжих халдварын тохиолдлыг бүртгэх, мэдээлэх журам
6. Сүрьеэ өвчнийг бүртгэх, мэдээлэх журмыг зургаадугаар, хорт хавдрыг бүртгэх, мэдээлэх журам
7. Хорт хавдрыг бүртгэх, мэдээлэх журам
8. Хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийг бүртгэх, мэдээлэх журам
9. Уламжлалт анагаахын тусламж, үйлчилгээний мэдээг бүртгэх, мэдээлэх журам
10. Эрүүл мэндийн **бүртгэлийн болон тайлангийн маягтын жагсаалт, хэн хөтлөх, хадгалах хугацааг**
11. Шинэчлэн боловсруулсан анхан шатны бүртгэлийн болон тайлангийн маягтын загвар




Нэг: Эрүүл мэндийн мэдээллийн мэргэжилтэн, биостатистикч, тархварзүйч эмчийн эрх

1. Сарын мэдээ, улирал, жилийн тайлан, эрүүл мэндийн мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох асуудлаар санал боловсруулж удирдлага болон дээд байгууллагуудад танилцуулах.
2. Сарын мэдээ, улирал, жилийн тайлан мэдээлэлд хайхрамжгүй хандсан (маягтыг буруу, дутуу хөтөлсөн, хугацаа хожимдуулсан, үндэслэл муутай мэдээлэл өгсөн), мэдээ тасалсан зөрчлийг цаг тухайд нь илрүүлж, хариуцлагагүй хандсан эмч, эмнэлгийн мэргэжилтэнг тухайн байгууллагын удирдлагад танилцуулж, хариуцлага тооцох санал оруулах.
3. Тухайн тайлангийн жилд статистик мэдээ, мэдээлэлд идэвх санаачлага, үр бүтээлтэй ажилласан ажилтныг урамшуулах ажлыг зохион байгуулж, тухайн байгууллагын удирдлагын зөвлөлийн түвшинд хэлэлцүүлж, шийдвэрлүүлэх

ХАВСРАЛТ 2

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН АЛБАН ЁСНЫ СТАТИСТИКИЙН МЭДЭЭ, ТАЙЛАН ГАРГАХ, МЭДЭЭЛЭХ ЖУРАМ





НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН
УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН **2022**

Маягтууд	мөрдөгдөж байсан маягт	Маягтын тоо			
		Хасагдсан маягт	Шинээр нэмэгдсэн маягт	Өөрчлөлт оруулсан маягт	Нийт
Өрх, сумын эрүүл мэндийн төвд хөтлөгдөх бүртгэлийн маягтууд	33		18	18	51
Амбулаторт хөтлөгдөх бүртгэлийн маягтууд	37		22	28	59
Стационарт хөтлөгдөх бүртгэлийн маягтууд	61		25	39	86



НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН
УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН **2022**

Маягтууд	мөрдөгдөж байсан маягт	Маягтын тоо			
		Хасагдсан маягт	Шинээр нэмэгдсэн маягт	Өөрчлөлт оруулсан маягт	Нийт
Сүрьеэгийн тасаг, кабинетад хөтлөгдөх бүртгэлийн маягтууд	14		4	11	18
БЗДХ/ДОХ-ын тасаг, кабинетад хөтлөгдөх бүртгэлийн маягтууд	12		5		17
Сэтгэц эмгэг судлалын тасаг, кабинетад хөтлөгдөх бүртгэлийн маягтууд	3		2		5



НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН
УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН **2022**

Маягтууд	мөрдөгдөж байсан маягт	Маягтын тоо			
		Хасагдсан маягт	Шинээр нэмэгдсэн маягт	Өөрчлөлт оруулсан маягт	Нийт
ЦССҮТ, цусны кабинетад хөтлөгдөх бүртгэлийн маягтууд	6		12	5	18
Зоонозын өвчин судлалын төв, салбаруудад хөтлөгдөх бүртгэлийн маягтууд			6		6
ЭСҮТ, эмгэг судлалын кабинетад хөтлөгдөх бүртгэлийн маягтууд	5		7	4	12



Шинэчлэн боловсруулсан тайлангийн маягтууд

Маягтууд	мөрдөгдөж байсан маягт	Маягтын тоо			
		Хасагдсан маягт	Шинээр нэмэгдсэн маягт	Өөрчлөлт оруулсан маягт	Нийт
Өрхийн эмнэлгийн тайлан ЭМТ-101	18		2	6	20
Сумын эмнэлгийн тайлан ЭМТ-102	40		10	17	50
Халдварт бус өвчний эрт илрүүлгийн тайлан ЭМТ-103	9	-	-	-	9
Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын жилийн үйл ажиллагааны тайлан ЭМТ -201	43	-	14	29	57
Хувийн эмнэлгийн үйл ажиллагааны тайлан ЭМТ-202	19	-	2	4	21
Сувиллын үйл ажиллагааны тайлан ЭМТ-203	8	-	-	-	8
Эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн тайлан ЭМТ-401	7	2	-	5	5
Эрүүл мэндийн байгууллагын хүчин чадлын тайлан ЭМТ-402	-	-	-	-	2
Бүгд	144	2	30	61	172



Хавсралт 11 – заавар

Тав хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр / Жишээ заавар/

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН
УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН **2022**

- **Маягтын нэр:** ТАВ ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДЭВТЭР
- **Маягтын дугаар:** ӨЭ-1.А
- **Ойлголт, тодорхойлолт:** Энэхүү дэвтэр нь эх, хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжлийн байдлыг дэмжих, үнэлэх зориулалттай бүртгэл юм. Тав хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр бол жирэмсэн эмэгтэй болон хүүхдийн эрүүл мэнд, өсөлт ба хөгжлийг бүртгэх үндсэн баримт болно.
- **Нөхөх заавар:** Тав хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн **улаан хүрээтэй хуудсуудад** Эрүүл мэндийн ажилтан, **цэнхэр хүрээтэй хуудсуудад** Эцэг, эх, асран хамгаалагч тэмдэглэл хөтөлж бөглөнө.
- Уг дэвтэр нь жирэмсэн эх болон хүүхдийн эрүүл мэндийн байдал, өсөлт хөгжлийг бүртгэх үндсэн баримт бөгөөд жирэмсэн эх өөрийн эрүүл мэндийн талаарх мэдээллийг уншиж танилцан **эхийн заавал мэдэж байх зүйлс**, ямар тохиолдолд хэнд хандан зөвлөгөө авах, хүүхдийг нярай үеэс нь эхлэн насны онцлогт тохируулан хэрхэн асрах, яаж хооллох тухай зөвлөмжүүд орсон тул жирэмсэн эх болон хүүхдийг асран хамгаалж буй хэнч гэсэн хэрэглэн мэдээлэл авах боломжтой.
- Тав хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийг **өрх, сумын эрүүл мэндийн төвд олгоно**. Хүүхдийн төрсөн өдрөөс нь эхлэн төрөлтийн талаарх мэдээллийг **амаржих газрын эх барьж авсан эмч эх баригч, эрүүл мэндийн ажилтнууд хөтөлж эхэд нь хүлээлгэж өгнө**. Гэр бүл эцэг эх хүүхдийнхээ эрүүл мэнд өсөлт бойжилтын талаарх мэдээллийг өөрсдөө тэмдэглэн эмнэлэгт ирэхдээ авчран эмчдээ үзүүлж хүүхдийнхээ талаар зөвлөгөө авна.
- **Хадгалах хугацаа:** байнгийн



Хавсралт 11 – заавар

Тав хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр / Жишээ заавар/

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН
УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН **2022**

Эрүүл мэндийн байгууллага

-Эрүүл мэндийн байгууллага нь “5 хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-ийг хэрэглэх **сургалтанд холбогдох эмч, мэргэжилтнүүдийг заавал хамруулна.**

-Сургалтад хамрагдсан өрх, сум, амаржих газрын эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь бусаддаа “5 хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-ийг хэрхэн ашиглах талаар **зааж өгөх** нь чухал.

“5 хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-ийг олгохдоо эцэг эх, асран халамжлагч нарт дэвтэр ашиглах, хөтлөх, хадгалах талаар **зөв мэдээллийг өгнө.**

- Эх, хүүхдэд тусламж үзүүлдэг эрүүл мэндийн бүх байгууллагад “5 хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-ийн **хангалттай нөөцтэй** байж эцэг эхчүүдэд тасралтгүй хангах шаардлагатай.



“5 хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-ийг хэзээ олгох бэ?

1. Жирэмсэн эмэгтэй анх удаа хяналтад ороход
2. Нэг хүртэлх настай хүүхдэд уг дэвтэр байхгүй бол
3. Эцэг эх дэвтрийг хаяж үрэгдүүлсэн тохиолдолд харьяа өрхийн эрүүл мэндийн байгууллага “5 хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-ийг олгож шаардлагатай мэдээллийг нөхөж бөглөж өгнө.



Хавсралт 11 – заавар

Тав хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр / Жишээ заавар/

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН
УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН **2022**

- **Тав хүртэлх хүүхдийн эрүүл мэндийн хяналт**
- **Хүүхдийн хяналт:** Эмнэлгийн мэргэжилтэн хүүхдийг эхийн хэвлийд бүрэлдэх үеэс эхлээд 6 нас хүртэлх өсөлт хөгжил, хоол тэжээл, хүүхдийн хөгжил, эрүүл мэндийн байдлыг хянаж үнэлэн, дэвтэрт тэмдэглэнэ.
- Эмнэлгийн мэргэжилтэн **эрүүл** хүүхдийг Эрүүл мэндийн сайдын баталсан гэрийн эргэлтийн төлөвлөгөөний дагуу үзнэ.
- 1 хүртэлх сартай хүүхдийг сард 4 удаа,
- 2 сартай хүүхдийг сард 2 удаа,
- 3 сартайгаас 1 нас хүртэл сар тутам,
- 1-2 настай хүүхдийг улиралд нэг удаа гэрээр эргэнэ.
- Санамж: **Гэрийн эргэлтийг заавал гэрт очиж хийнэ.**
- Гэрийн эргэлт бол эрүүл хүүхдийн хяналт гэдгийг сана.
- Эмнэлгийн мэргэжилтэн гэрийн эргэлтээр хүүхдийн биеийн байдал, хоол тэжээл, өсөлт хөгжил, хүүхдийн хөгжил, гэрийн таатай орчин, аюулгүй байдал, эцэг эх, ах, эгчийн сэтгэл санааны байдал, шинэ хүүхэддээ хэрхэн дасах зэрэг олон зүйлийг хянаж үнэлэн тохирсон зөвлөгөө, мэдээлэл өгөх юм.
- Эмнэлгийн мэргэжилтэн гэрийн эргэлт болон эрүүл мэндийн байгууллагад хүүхдийг ирэх үед нь эрүүл мэндийн байдлыг тухайн насанд тохирсон гэрийн эргэлтийн үнэлгээний хуудсаар хянаж, эрүүл мэндийн талаар “5 хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр”-т тэмдэглэнэ.
- Хэрвээ хүүхэд гэрийн эргэлтийн үед өвчтэй байвал **ХӨЦМ**-ийн дагуу үнэлж эмчилгээг шийднэ.



- **Анхаар:** ХӨЦМ-ийн дагуу үнэлэх боломжгүй бол Өвчний карт нээн тэмдэглэл хөтлөн эмчилгээний асуудлыг шийд. “5 хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр” бол эрүүл хүүхдийн хяналтын дэвтэр **өвчний карт биш гэдгийг сана.**
- **Нэг хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн хяналт**
Нярайн эрүүл мэндийн хяналт:
 - Амаржих газраас гэртээ гарсаны дараах 24-72 цагийн дотор гэрийн эргэлт хийж, нярайд эрүүл мэндийн үнэлгээ хийнэ.
 - Энэ бол гэрийн анхны эргэлт юм.
 - Анхны гэрийн эргэлтийг **эмч, сувилагч хамт** хийнэ.
 - Анхны эргэлтээр эх, нярайн эрүүл мэндийг хамт хянанана.
 - Эргэлтээр төрсний дараах 24-72 цагийн гэрийн эргэлтийн өмнөх асуумж, эрүүл мэндийн ажилтанд зориулсан эргэлтийн үнэлгээний дагуу нярайн эрүүл мэндийн байдлыг үнэлж, эцэг эхэд өгөх зөвлөмжийг ашиглан зөвлөгөө өгнө.



Хавсралт 11 – заавар

Тав хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр / Жишээ заавар/

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН
УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН **2022**

- **Эрүүл мэндийн ажилтанд зориулсан гэрийн эргэлтийн үнэлгээний хуудас хөтлөх заавар**
- Паспортын хэсгийг эцэг эхээс асууж үнэлнэ. Эцэг эх хүүхдийн нэр, харилцах хэлийг сонгож тэмдэглэнэ. Гэрийн эргэлтээр очсон он сар өдрийг тэмдэглэнэ.
- Өсөлтийг хэмжиж тэмдэглэнэ: Хүүхдийн биеийн жинг хэмжин, килограммаар бичнэ. Жишээ нь: хүүхдийн жин **3 кг 700 гр байвал 3.7 кг** гэж бичнэ.
- Хүүхдийн биеийн уртыг хэмжин тэмдэглэнэ: Уртын хэмжээг сантиметрээр бичнэ. Жишээ нь: хүүхдийн өндөр **1 метр 12 см байвал 112 см** гэж бичнэ.
- Хүүхдийн жин, уртын харьцааг тодорхойлно: Биеийн жинг урт/өндөрт нь харьцуулсан харьцааг хэлнэ. Энэ үзүүлэлтээр туранхай, илүүдэл жин, таргалалтыг илрүүлэх ач холбогдолтой. Мөн хүүхдийн хоол тэжээлийн цочмог дутлыг тодорхойлдог.



Хавсралт 11 – заавар

Тав хүртэлх насны хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр / Жишээ заавар/

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН
УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН **2022**

- Хүүхдийн биеийн урт/өндөр-насны үзүүлэлт нь: 2 хүртэлх насны хүүхдэд уртыг, 2-оос дээш насны хүүхдэд өндрийг хэмжиж, насанд нь харьцуулсан харьцааг хэлнэ. Энэ үзүүлэлтээр **хүүхдийн "өсөлт хоцролт"**, намханыг тодорхойлно. Хүүхэд хэт өндөр байх нь ховор тохиолдох бөгөөд энэ нь дотоод шүүрлийн эмгэг байж болзошгүйг илтгэнэ.
- Хүүхдийн биеийн жин-насны үзүүлэлт нь хүүхдийн биеийн жинг насанд нь харьцуулсан харьцааг хэлнэ. Энэ үзүүлэлтээр **"тураал"-ыг** илрүүлдэг. Энэ үзүүлэлтээр илүүдэл жин, таргалалтыг үнэлэхгүй.
- Хүүхдийн жин-урт/өндрийн үзүүлэлт нь биеийн жинг урт/өндөрт нь харьцуулсан харьцааг хэлнэ. Энэ үзүүлэлтээр **"туранхай"-г** илрүүлдэг. Энэ үзүүлэлтээр илүүдэл жин, таргалалтыг илрүүлэх ач холбогдолтой. Энэ үзүүлэлт дээр хүүхдийн хоёр хөлийн хаванг заавал шалгаж тэмдэглэнэ. Энэ нь хүүхдийн хоол тэжээлийн цочмог дутлыг тодорхойлдог.
- Хүүхдийн өсөлтийг үнэлэх хүснэгт нь 2 өөр өнгөтэй.
- **Цэнхэр хүснэгтийг эрэгтэй, ягаан хүснэгтийг эмэгтэй** хүүхдийн өсөлтийг үнэлэхэд ашиглана.
- Өсөлтийн хүснэгт дэх ногоон шугам болох **"голч шугам"** өсөлтийн дунджийг заана.
- Өсөлтийн хүснэгт дэх ногоон, шар, улаан, хар шугамуудыг 2 онооны шугам гэж нэрлэдэг. Өсөлтийг тэмдэглэсэн цэгэн тэмдэглэл нь голч ногоон шугам руу ойртох тусам сайн үзүүлэлт, алслагдах тусам өсөлтийн асуудалтайг илэрхийлнэ.
- Өсөлтийн хоёр буюу түүнээс олон цэгэн тэмдэглэлийг хооронд нь зураасаар холбосон холболтыг **өсөлтийн муруй** гэнэ. Энэ муруйгаар хүүхдийн өсөлтийн хандлагыг тодорхойлно.



Сувилагч тусгай мэргэжилтний хөтлөх маягт

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН
УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН **2022**

Бүртгэлийн маягт	НИЙТ	Хэн хөтлөх	
		Эмч	Сувилагч, тусгай мэргэжилтэн
Өрх сумын ЭМТ-н бүртгэлийн маягт	51	43	28
Амбулаторт хөтлөгдөх маягт	59	56	10
Стационарт хөтлөгдөх маягт	99	84	46
төрөлжсөн мэргэжлийн кабенитууд	78	68	42
Нийт	287	251	126



Эрүүл мэндийн салбарт хэрэглэгдэж байгаа программ хангамжууд / **онлайн** /

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН
УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН **2022**

1. **Hinfo3.0** - өвчлөл эндэгдэлийн мэдээллийн нэгдсэн сан
2. **Ewar 2.0** - халдварт өвчний мэдээллийн сан
3. **Tandalt. Ehemut. Mn** - Эх хүүхдийн өвчлөл эндэгдэлийн тандалт
4. **Эрүүл мэндийн сарын мэдээ**
5. **Flu.mn**/Томуугийн харуулдан тандалтын мэдээ
6. **burtgel.mohs.mn** – өдөр тутмын мэдээлэл
7. **E health .mn** – эмнэлгийн дотоод бүртгэлийн систем
8. **Health.gov.mn** – жор, дархлаажуулалт, нэг иргэн нэг бүртгэл, даатгалын мэдээлэл
9. **VHS**- эрт илрүүлгийн программ хангамж
10. **E hospital** - үйл ажиллагааны бүртгэл мэдээлэл / сургалт/

Асуудал

- Хүн амын эрүүл мэндийн байдал, эмнэлгийн тусламж үйлчилгээний мэдээ мэдээллийг эрүүл мэндийн салбарт ашиглагдаж байгаа программуудаар нэгтгэн цуглуулж байгаа боловч **нэгдмэл байдал одоохондоо хангагдаагүй** байна. / тус бүр шивэлттэй- мэдээлэл бүр бүрэн хөрвөхгүй механик ажиллагаа ихтэй.
- Үйл ажиллагааны одоо цаг дээр бүртгэл мэдээлэл тогтмол хийгдэхгүй байгаа нь статистик эмч нартаа ачаалал үүсгэж / мэдээллийн сүлжээ, тоног төхөөрөмж, хүн хүч /
- **Эмч мэргэжилтнүүд** – мэдээллийн санг цаг хугацаанд нь үүсгэж байх /**БОЭТ, Өрхийн ЭМТ ЦЦ// МО,НО,ХҮ/**
- **Статистикч**- үүссэн мэдээллийн сангаас мэдээлэл нэгтгэх дамжуулах, боловсруулах



Мэдээллийн хэрэглээ, эргэн мэдээлэл

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН
УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН **2022**

- Сарын мэдээллийн дүгнэлтийг аймгийн, эмнэлгийн удирдлагуудад, вэб сайтад, eofficc, fase группүүдээр аль болох өргөн тархааж байгаа.
- Өдөр бүр ковидын мэдээ – 360 хоног
- 7 хоног бүрийн мэдээлэл -49 долоо хоног
- Сар бүрийн эргэн мэдээлэл -12 сар
- Улирал тутам мэдээллийн томхимол -4 гаргаж дамжуулж байна.
- Жилийн эцийн мэдээллийн ном
- 5-10 жилийн мэдээллийн ном
- Эрүүл мэндийн үзүүлэлтийн нугалбар
- Тухайн үеийн сургалт семинарт зориулсан танилцуулга мэдээлэл
- Эмч мэргэжилтнүүдийн судалгааны ажлын эмхэтгэл
- Байгууллага бүр өөрийн мэдээллээр эргэн мэдээлэл хийх / цөөн/


Асуудал:

1. Байгууллага бүр мэдээллийг харилцан адилгүй ашиглаж байна.- Сар тутамдаа танилцуулга- шийдвэр гаргахдаа нотолгоотой.
2. Өөрийн байгууллагад үүссэн мэдээллийн сангийн ашиглалтыг сайжруулах – үйл ажиллагаандаа дүгнэлттэй, төлөвлөлттэй байх




ӨМНӨГОВЬ АЙМАГ УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН -2022

ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ 1000 АМЬД ТӨРӨЛТӨД / СУМДААР




Үзүүлэлт		Өмнөговь			Улсын дүн		
		2020 он	2021 он	өөрчлөлт	2020он	2021 он	өөрчлөлт
0-1 насны хүүхдийн эндэгдлийн тоо		20	18	-2	878	829	-49
Үүнээс	1000 амьд төрөлтөд	11.9	10.9	-1	11.5	11,6	0,1
	Нярай үеийн эндэгдлийн эзлэх хувь	80	72.2	-7.8	67.9	71,3	3,4
	Үүнээс эрт нярай үеийн хувь	68.7	76.9	8.2	73.7	76,5	2,8
	Үүнээс хожуу нярай үеийн хувь	31.2	23	-8.2	26.3	23,5	-2,8
0-5 насны хүүхдийн эндэгдлийн тоо		24	20	-4	1065	993	-72
үүнээс	1000 амьд төрөлтөд	14.2	12.2	-2	14	13,9	-0,1




ӨМНӨГОВЬ АЙМАГ УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН -2022

ЖИРЭСНИЙ ЭРТ, ХОЖУУ ХЯНАЛТ / СУМДААР




ХҮҮХДИЙН ХЯНАЛТЫН ХУВЬ / СУМДААР




ӨМНӨГОВЬ АЙМАГ УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН -2022


ОХИДЫН ЖИРЭМСЛЭЛТИЙН ХУВЬ / СУМДААР



ОХИДЫН ТӨРӨЛТ /НАСААР/





ОХИДЫН ТӨРӨЛТИЙН ХУВЬ / СУМДААР




ӨМНӨГОВЬ АЙМАГ УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН -2022

ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЭРТ ИЛРҮҮЛЭГ СУМ/ ӨРХӨӨР




ХАЛДВАРТ БУС ӨВЧНИЙ ЭРТ ИЛРҮҮЛЭГ / ТӨРЛӨӨР




ӨМНӨГОВЬ АЙМАГ УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН -2022

СЭРГИЙЛЖ БОЛОХ НАС БАРАЛТ 10,000 ХҮН АМД / СУМДААР




ОСОЛ ГЭМТЛИЙН ӨВЧЛӨЛ 10000 ХҮН АМД / СУМДААР



ӨМНӨГОВЬ АЙМАГ УДИРДАХ АЖИЛТНЫ ЗӨВЛӨГӨӨН -2022

2021 ОНД БҮРТГЭГДСЭН КОВИД-19-Н ХАЛДВАР/ СУМДААР



КОВИД-19 ХАЛДВАРЫН ЭСРЭГ ДАРХЛААЖУУЛАЛТЫН 3-Р ТУНГИЙН ХАМРАЛТ



Дэвшүүлэх асуудал

- Сувилагч тусгай мэргэжилтнүүдийг төлөвлөлттэйгээр хангах бодлогыг байгууллага бүр авч хэрэгжүүлэх / *тэтгэвэрт, жирэмсэн, ажилаас гаргах, шилжилт хөдөлгөөн* /
- Эмч мэргэжилтнүүдийнхээ ажил ачааллыг зөв зохицуулах
- ЭМБ-д хэрэглэгдэж байгаа анхан шатны маягтуудын хангалт, бүртгэл хөтлөлтөд дотоод хяналт хийх / *ЭМС-н 611-р батлагдсан маягт мөн эсэх, дутуу буруу хөтлөлт*/
- Маягт хөтлөх / *үйл ажиллагааны мэдлэг чадвар* / сургалт тасралтгүй явуулах
- Мэдээллийн сан үүсгэлтийг цаг хугацаанд нь үнэн зөв бүрдүүлэхэд бүх ажилчдыг сургах, шаардлагатай зүйлсээр нь хангаж өгөх / *ком, сүлжээ, маягт, дэмжлэгт хяналт*/
- *Мэдээллийн хэрэглээг сайжруулах*- бусад удирдлага, салбарын бус хүмүүсийг мэдээллээр хангах, МСС-г хамгийн ойр статистикаар ойлгуулах.
- *Нотолгоонд суурилж төлөвлөлтөө хийх* – суурь түвшингээ зөв тодорхойлох.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Эрүүл мэндийн салбарын ажилтан- эрүүл мэндийн тогтолцооны
бүрэлдхүүн, эд эс мөн.